



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.02 № 01/681
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА Л.ДУЛАМХҮҮ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Ханх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Ханх сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Ханх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Ханх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Ханх сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Ханх сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (9. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Ханх сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Ханх сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт 9. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



**МОНГОЛ
АРДЫН НАМ**


**ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН РЕФОРМ**

2024-2028 ОН

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ХӨВСГӨЛ АЙМАГ ХАНХ СУМ

2024 он



Үндэслэл:

- ✓ Намын гишүүд дэмжигчдийн өдөрлөгөөс ирүүлсэн санал
- ✓ “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр
- ✓ “Хөгжсөн Хөвсгөл 2030” хөтөлбөр
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд Монгол Ардын Намаас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого бүсчилсэн хөгжлийн реформ” мөрийн хөтөлбөр
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

Уриа:

ИРГЭДИЙН ОРОЛЦОО-ХАНХЫН ХӨГЖИЛ



НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл мэнд


- 1.1.1 Сумын эрүүл мэндийн төвийн барилгыг стандартын дагуу бүрэн шинэчилнэ
- 1.1.2 Эмч, сувилагч болон хэрэгцээтэй байгаа мэргэжилтэнүүдийг сумын бодлогоор дэмжиж сургана.
- 1.1.3 Эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана
- 1.1.4 Хүүхэд, ялангуяа нялхасын эндэглийг тууштай бууруулж “Хүүхдэд ээлтэй сум” зорилтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.1.5 Суманд шүдний эмчийг гэрээгээр улирал тутам ажиллуулна.
- 1.1.6 Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг эрчимжүүлж иргэдийг эрүүл амьдрах хэв маягт тохирсон сургалтуудыг үе шаттай тогтмол явуулж хэвшүүлнэ.
- 1.1.7 Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг эрчимжүүлж иргэдийг эрүүл амьдрах хэв маягт тохирсон сургалтуудыг үе шаттай тогтмол явуулж хэвшүүлнэ.
- 1.1.8 “Хавдрын эсрэг хамтаа” “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2 Боловсрол

- 1.2.1 Бага ангийн сурагчдын сурах орчныг сайжруулна.
- 1.2.2 Сургуулийн автомашиныг шинэчилнэ
- 1.2.3 Дотуур байрын их засвар хийнэ.
- 1.2.4 ЕБС- д сэтгэл зүйчийг ажиллуулах саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлэнэ.
- 1.2.5 Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ.

1.3 Хүүхэд

- 1.3.1 Хүүхдийн амьдрах, сурах, хөгжих боломжтой бүх шатны арга хэмжээг бодлогоор хэрэгжүүлж олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.3.2 Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.3 Хүүхдийн бодит оролцоо, хэрэгцээнд суурилсан хөгжлийн үйлчилгээг дэмжинэ.



1.3.4 Эрсдэлт нөхцөлд байгаа болон хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх арга хэмжээ авч, хариу үйлчилгээ, хяналтыг сайжруулна.

1.3.5 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөл байдал тулгарсан үед авах арга хэмжээний мэдлэг, чадавхийг хүүхэд, өсвөр үеийнхэнд төлөвшүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.

1.4 Гэр бүл

1.4.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.

1.4.2 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод чиглэсэн үйлчилгээ, орчин нөхцөлийг стандартад нийцүүлж, хамтарсан багийн ажлын үр нөлөөг дээшлүүлнэ.

1.4.3 “Хүүхэд хамгааллын бодлого” батлан хэрэгжүүлэх, эцэг, эхийн зөвлөл ажиллуулах, ажилтны гэр бүлийг дэмжих соёлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хэвшүүлнэ.

1.4.4 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг бодлогоор хэрэгжүүлнэ.

1.4.5 Ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг жижиг дунд бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх бодлого тусгайлан боловсруулж хэрэгжүүлнэ.

1.5 Бусад

1.5.1 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.

1.5.2 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээхэд дэмжлэг үзүүлнэ.


1.5.3 Ахмадын байрны засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.

1.5.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.5.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний жишиг төвийг дэмжинэ.

1.5.6 Төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1.6 Соёл




Official stamp and signature. The stamp is rectangular with a pink border and contains the text "МОНГОЛЫН ХУУЛЬ" (Mongolian Law) and "0000000004". The signature is handwritten in black ink.

- 1.6.1 Соёл урлагийн салбарын хүний нөөцийн чадавхуулж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар стандарт хангасан чанартай, хүртээмжтэй үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.2 Соёлын төвийн барилгыг стандартын дагуу шинээр барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.6.3 Соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг олшруулж, гадаад дотоодын аялагчдад зориулсан хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 1.6.4 Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа түүхийн болон байгалийн дурсгалт газруудыг нэгдсэн бүртгэлд бүрэн хамруулж, олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 1.7 Спорт
- 1.7.1 Нийтийн биеийн тамирын хөгжих боломжтой төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.
- 1.7.2 Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, дэд бүтцийг байгуулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ТОГТВОРТОЙ ХАНГАХ БОДЛОГО

- 2.1. Хөдөлмөр эрхлэлт, шинэ ажлын байр
- 2.1.1 Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.1.2 Хувийн хэвшил, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих замаар шинэ ажлын байрыг бий болгох
- 2.1.3 Хувиараа хөдөлмөр эрхэлж буй болон бизнесээ эхэлж буй иргэдэд чиглэсэн зөвлөн туслах, ажлын байр нэмэгдүүлэх ахуйн үйлчилгээний төвийг байгуулна.
- 2.1.4 Орон нутгийн онцлогт нийцүүлэн үйлдвэрлэл хийж буй өрхийн бизнес эрхлэгчдийг дэмжих
- 2.1.5 Өрхийн бичил бизнесийг дэмжиж, Сум хөгжүүлэх сан, Нутгийн иргэдийн удирлагатай зээлийн эргэлтийн сангийн зээлийг үр ашигтай ашиглах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.2 Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин



0000000005

- 2.2.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, сангуудын хөрөнгийн үр ашгийг дээшлүүлнэ.
- 2.2.2 “Нутгийн бренд” үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, сумын бренд бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан патентжуулна.
- 2.3 Дэд бүтэц
- 2.3.1 Эрчим хүчний дэд бүтцийг нэмэгдүүлнэ.
- 2.3.2 Сумын төвийн гэрэлтүүлгийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 2.3.3 Олон улсын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Хөвсгөл нуурын зүүн эргээр дагасан 110 км хатуу хучилттай авто замыг шинээр барих (Ханх сумаас Хатгал тосгон хүртэлх чиглэлд)
- 2.3.4 Сумын төвийн болон хөдөөгийн багуудын замыг ОНХС-ийн хөрөнгөөр үе шаттайгаар засварлана.
- 2.3.5 Хөдөөгийн багуудад үүрэн телефоны сүлжээг сайжруулах зорилгоор дахин дамжуулах станцуудыг шинээр байршуулна.
- 2.3.6 Аялал жуулчлалын бүсүүдийг найдвартай эрчим хүчний эх үүсвэрээр хангана.
- 2.3.7 Байгалийн үзэсгэлэнт газруудад завины зогсоол шинээр барина.
- 2.3.8 Шинээр байгуулагдсан хог хаягдлын цэгийн менежментийг зөв зохистой хэрэгжүүлнэ.
- 2.4 Дөрвөн улирлын аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл
- 2.4.1 Аялал жуулчлалын чиглэлийн мэргэжлийн боловсон хүчнийг бодлогоор бэлтгэнэ.
- 2.4.2 Байгалийн аялал жуулчлал, аялал жуулчлалын гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл зэрэг төрөлжсөн сургалтуудад иргэдийг хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 2.4.3 Байгаль орчинд ээлтэй эко аялал жуулчлалын “Хөх баавгай” төслийг хэрэгжүүлнэ.
- 2.4.4 Аялал жуулчлалын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.4.5 Өвлийн саруудад зохион байгуулдаг арга хэмжээний тоог нэмэгдүүлнэ.



1720090001-0070605
00000000006

2.4.6 Соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын салбарын орлогыг нэмэгдүүлж орон нутагт үлдэх өгөөжийг нэмэгдүүлнэ.

2.4.7 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.5 Эрүүл хүнс

2.5.1 Төмс, хүнсний ногоо тариалах, хүлэмж, агуулахын аж ахуй, өрхийн үйлдвэрлэлийг дэмжин сумын иргэдээ чанартай эрүүл хүнсээр хангах бодлого хэрэгжүүлнэ.

2.5.2 Мал тарилгын хашаа, угаалгын банныг нэмэгдүүлж мал эрүүлжүүлэх ажлыг бодлогоор хэрэгжүүлнэ.

2.5.3 Хүнсний дэлгүүрүүдийн хүнс хадгалах, худалдаалах орчин нөхцөлийг стандартын дагуу тохижуулах ажлыг хэрэгжүүлнэ.

2.6 Мал аж ахуй

2.6.1 “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг сумын хэмжээнд өрнүүлж, иргэд хоршоолохыг дэмжинэ.

2.6.2 Залуу малчин өрхүүдийг малжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.7 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

2.7.1 Малын үүлдэр угсааг сайжруулах ажлыг зохион байгуулж ОНХС-ийн хөрөнгөөр сайн үүлдрийн эцэг мал авна.


2.7.2 Гадаад дотоодын жуулчдыг малчин өрхөөр зочлуулах арга хэмжээг зохион байгуулах, нүүдлийн соёл, бэлчээрийн мал аж ахуйг сурталчлах үүнээс орлого олох боломжийг бий болгох

2.7.3 Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний “Нутгийн брэнд” үйл ажиллагааг жил бүр зохион байгуулах

ГУРАВ. ШУДАРГА ИРГЭНИЙ ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ

3.1 Хүний эрх


3.1.1 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.



- 3.1.2 Төрийн байгууллагын шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн аливаа шийдвэр гаргахгүй байхад анхаарна.
- 3.1.3 Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгож, бүх түвшинд хүйсийн тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтална.
- 3.1.4 Зайлшгүй шаардлагатай асуудлаар хяналт хийх “ Нээлттэй сонгогч”-ыг зохион байгуулж, иргэдийн мэдэх эрхийг хангана
- 3.2 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
- 3.2.1 Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, бүх нийтийн шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулан чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх “Сургалт”, “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.2.3 Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид, дарамтгүй ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 3.3 Ухаалаг “E-Mongolia” AI шинэчлэл- Цахим засаглал
- 3.3.1 Цахим хөгжлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, төрийн бүх үйлчилгээг цахимжуулснаар ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, хүнд суртал, авлигаас ангид сум болно.
- 3.3.2 Төрийн бүх үйлчилгээ цахим хэлбэрт шилжүүлж, “ E- Mongolia” системийг хөгжүүлж, төрийн үйлчилгээг шат дамжлагагүй хүргэнэ.
- 3.3.3 Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулан шилэн ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 3.4 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ
- 3.4.1 Олон нийтийн гудамж, зам, талбайн эрсдэлтэй газруудыг бүрэн камержуулах
- 3.4.2 Сумандаа “ХУРДАН” төвийн үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх

ДӨРӨВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

- 4.1 Уламжлалт нүүдлийн аж ахуй ба сорилт бэрхшээл
- 4.1.1 Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ авна.



4.1.2 Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сүргийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг нэгтгэсэн стандартыг нэвтрүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулна.

4.2 Ногоон эдийн засаг

4.2.1 Хог хаягдлыг бууруулах, байгалийн нөөцийг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, дахин боловсруулж, ашиглах санаачилгуудыг дэмжин байгальд ээлтэй техник технологийг нэвтрүүлж, ногоон бүтээгдэхүүн, тогтвортой хэрэглээ, амьдралын ногоон хэв маягт тулгуурласан “Тойрог” эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

4.2.2 Ногоон технологи, инновац, судалгаа шинжилгээ, гарааны бизнес, ногоон ажил эрхлэлтийг дэмжин, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

4.2.3 Ухаалаг, хэмнэлттэй хэрэглээ, байгальд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

4.2.4 Ногоон хөгжлийн шийдэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боловсролын компанит ажлыг хэрэгжүүлнэ.

ТАВ. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1 Хойд бүсийн хөгжил

5.1.1 Бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах хөтөлбөрт хамтран ажиллана.


5.1.2 Ханх боомтын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

5.2 Ханх сумын хөгжлийн төлөвлөлт

5.2.1 Сумын хөгжлийн төлөвлөлтийг баг тус бүрээр хийж, хэрэгжүүлж ажиллана.:

5.2.2 Байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ухаалаг хэрэглээг төлөвшүүлж дэлгэрүүлэх, байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг дэмжин ажиллана.

ХАНХ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



0000000009